



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилчдын төлөөллөөс гаргасан гомдол, үүссэн нөхцөл байдлыг судалж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

Ц.Түвшинзаяа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга

Гишүүд:

М.Баярмаа

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Билгүтэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Т.Мөнхбаяр

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Мэдээлэл, технологийн албаны ажилтан


Нарийн бичиг:

М.Баярцэцэг

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн

2. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилчдын төлөөллөөс гаргасан гомдол, үүссэн нөхцөл байдлыг судалж, санал дүгнэлт боловсруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс хуанлын 10 хоногт багтаан зохион байгуулахыг Ажлын хэсэг (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

ТӨБЗГ тушаал-/2022

132013475

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
даргын 2022 оны 12 дугаар сарын  
23 өдрийн 1/24 дугаар тушаалын хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

### Нэг. Нийтлэг үндэслэл

“Засгийн газрын автобааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын хамт олны төлөөллөөс ирүүлсэн өргөдөл гомдлыг судалж, шалгалт хийх, үүссэн нөхцөл байдлыг судалж, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

### Хоёр. Шалгах ажлын хамрах хүрээ

Өргөдөл, гомдолд дурдсан дараах асуудлыг нягтлан шалгах ажлыг гүйцэтгэнэ.  
Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хураан төвлөрүүлсэн автомашиныг хувьдаа ашигласан гэх мэдээллийг шалгаж, баримтын шалгалт хийх;
2. Автомашины сэлбэг, засвар үйлчилгээний зардлаас хувьдаа завшсан гэх мэдээллийг шалгаж, баримтын шалгалт хийх;
3. Монгол даатгалын компаниас олгосон нөхөн төлбөрийг “Очух” ХХК-ийн дансанд шилжүүлэн авсан гэх мэдээллийг шалгаж, баримтын шалгалт хийх;
4. Албан томилолтын журмыг дагаж мөрдөөгүй талаарх мэдээллийг шалгаж, баримтын шалгалт хийх;
5. Хувийн мал аж ахуйн тэжээл, хивгийг байгууллагын зардлаас гаргасан гэх мэдээллийг шалгаж, баримтын шалгалт хийх;
6. “Магнай трейд” ХХК-тай хийсэн шатахууны гэрээнд ашиг сонирхлын зөрчил үүссэн байх магадлалтай гэх мэдээллийг шалгаж, баримтын шалгалт хийх;
7. Автомашин худалдан авалт хийхдээ зах зээлийн үнээс хэт өндөр үнээр авсан гэх мэдээллийг шалгаж, баримтын шалгалт хийх.

### Гурав. Үр дүн, хугацаа

Ажлын хэсгийн шалгалтын тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх санал дүгнэлтээ 2023 оны 1 дүгээр сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад танилцуулах.

---o0o---